



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 1 дүгээр сарын 19 өдөр Дугаар 05

Хэрлэн сум



V ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 5 дугаар хуралдаан 2021 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн 14:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 91,7 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

- 1.Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Цагаан сарын баярыг улсын хэмжээнд нийтээр тэмдэглэхгүй байх тухай” 02 дугаар тогтоолыг танилцуулах,
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар
- 2.Олон нийтийн газраар бага насны хүүхэд дагуулж явахгүй байх талаар авч хэрэгжүүлэх ажлын санал танилцуулах,
АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс
- 3.Ерөнхий боловсролын сургууль, жолооны курс, дамжаа бусад сургалтын төвүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалтын ажил зохион байгуулсан тухай дүгнэлт танилцуулах,
Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар
- 4.Багийн иргэдийн нийтийн хурал зохион байгуулах журмын төсөл танилцуулах,
АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
- 5.Хот хооронд зорчих хүсэлтэй иргэдийн талаар авах арга хэмжээний талаар хэлэлцэх,
Эрүүл мэндийн газар
- 6.Аймгийн Онцгой комисст иргэд, аж ахуй нэгж байгууллагуудаас ирүүлсэн хүсэлт, албан бичгийг танилцуулах,
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар
- 7.Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн мэдээлэл танилцуулах,
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

/  / М.Бадамсүрэн
/  / Э.Ганжигүүр

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Онцгой комиссын гишүүн П.Бат-Өлзий-д:

- 1.1."Цагаан сарын баярыг улсын хэмжээнд нийтээр тэмдэглэхгүй байх тухай" аймгийн Засаг даргын захирамж боловсруулж гаргахыг,
1.2.Иргэдэд зөвлөх, уриалга гаргах талаар чиглэлийг захирамжид тусгахыг,

АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Э.Эрдэнэбилэг,

АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн О.Гүнтамир нарт:

- 1.3."Цагаан сарын баярыг улсын хэмжээнд нийтээр тэмдэглэхгүй байх тухай" Олон нийтийн байгууллагын удирдлагуудтай "иргэдэд зөвлөх, уриалга гаргах" талаар уулзалт зохион байгуулахыг,
1.4."Цагаан сарын баярыг улсын хэмжээнд нийтээр тэмдэглэхгүй байх тухай" зөвлөмжийг сумын Засаг дарга нарт чиглэл өгөхийг,

Хоёр.АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Э.Эрдэнэбилэг-т:

- 2.1."Хүүхдийн эрхийг хамгаалах, эрсдлээс урьдчилан сэргийлэх тухай" аймгийн Засаг даргын албан даалгавар гаргахыг,

Гурав.Боловсрол, соёл урлагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн А.Нансалмаа-д:

- 3.1.Ерөнхий боловсролын сургуулийн зөвшөөрөгдсөн танхимын сургалтыг зохион байгуулахад анхаарах чиглэлийг албан бичгээр сумын Засаг дарга нарт хүргүүлэхийг,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа-д:

- 3.2.Ерөнхий боловсролын сургуулийн удирдлагуудад сургалтыг 1 танхимд 10-аас ихгүй суралцагч байх талаар албан шаардлага хүргүүлэхийг,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа нарт:

- 3.3.Хяналт шалгалтын ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн халдвар хамгааллын шаардлага хангасан Гэр бүл, хүүхэд залуучуудын газрын дэргэдэх шатар, англи хэл, хөгжмийн дугуйлан, Түгээмэл оюу сургуулийн дэргэдэх Тояа академийн сургалт, Монголын оюун ухаан академийн Дорнод аймаг дахь салбар Кристалл төв, Дорнын амжилт сургалтын төвийн үйл ажиллагааг эхлүүлэхийг,

- 3.4.Зөвшөөрсөн сургалтын төвүүдэд явцын хяналтыг зохион байгуулж ажиллахыг,

 / М.Бадамсүрэн
 / Э.Ганжигүүр

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,
Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч,
Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир нарт:

3.5.Зөвшөөрсөн сургалтын төвийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа-д:

3.6.Аж, ахуйн нэгж байгууллагын мөрдөгдөх норм, стандартыг цаашид мөрдүүлэхэд хяналт тавих ажиллахыг эрчимжүүлэх,

Дөрөв.АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,
Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ-д:

4.1.Сум, багийн иргэдийн нийтийн хурал зохион байгуулах, чиглэл авах талаар Засгийн газрын хэрэг эрхлэх газарт албан бичиг уламжлахыг,

Тав.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга,
Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
цагдаагийн хурандаа Т.Ганзориг нарт:

5.1.Нийслэл Улаанбаатар хотоос Дорнод аймгийн харьяалалтай иргэдийг 2021 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр татан авахад шаардлагатай 1 автобус Улаанбаатар хот руу явуулахыг зөвшөөрөв,

Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Мөнхтөр-д:

5.2.Шаардлагатай тохиолдолд Улаанбаатар хотоос Дорнод аймагт иргэдийг татах автобусын бэлтгэл бэлэн байдлыг хангаж ажиллахыг,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
цагдаагийн хурандаа Т.Ганзориг,
сумын Засаг дарга нарт:

5.3.Улаанбаатар хотоос Дорнод аймгийн иргэдийг татан авахтай холбогдуулан гэрийн тусгаарлан ажиглалтын бэлтгэл бэлэн байдлыг хангахыг,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа нарт:

5.4.Улаанбаатар хотоос Дорнод аймгийн иргэдийг татан авахтай холбогдуулан тусгаарлах байрны бэлтгэл бэлэн байдлыг хангахыг,

 / М.Бадамсүрэн
 Т.Ганжигүүр

Зургаа. Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа.

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах.
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг.

6.1. "Петрочайна дачин тамсаг" ХХК-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн "Улаанбаатар хотоос Дорнод аймагт БНХАУ-ын иргэн 9 ажилтанг нэвтрүүлэх" хүсэлтийн дагуу аймгийн төвд 7 хоног тусгаарлалтыг зөвшөөрсөн тохиолдолд халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж нэвтрүүлэх,

АЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн В.Цэнгэлмаа-д.


6.2. Авто тээврийн төвөөс аймгийн Онцгой комисст ирүүлсэн "Халдвар хамгааллын хэрэгслийн дэмжлэг хүсэх тухай" хүсэлтийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлэхийг,

Долоо. Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д.

7.1. Хяналтын цэгт үүрэг гүйцэтгэж буй албан хаагчдын дархлааг дэмжих зорилгоор витагрип 200 ширхэгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас Эрүүл мэндийн газарт олгохыг,

7.2. Хяналтын цэгт үүрэг гүйцэтгэж буй албан хаагчдын дархлааг дэмжих зорилгоор чацаргана 30 кг Хөлөнбуйр хяналтын цэгт, чацаргана 30 кг Баянхошуу хилийн боомтод, чацаргана 30 кг Эрээнцав хилийн боомтод, чацаргана 10 кг Шуурхай штабт олгохыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН
ДАРГА  М.БАДАМСҮРЭН

БҮСИЙН ТӨВ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН
ПРОГРАММ, ТЕХНИК ХАНГАМЖ ХАРИУЦСАН
ИНЖЕНЕР, АХМАД  Э.ГАНЖИГҮҮР